



ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР,
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ



ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН
СУРГАЛТ, ҮНДЭГЭЭ, СУВАНГАЛЫН
ИНСТИТУТ

ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

2024 оны IV улирал

Улаанбаатар хот

Тойм бэлтгэсэн: Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ,
судалгааны институт,
Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын судалгааны сектор

Хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Нарны зам, 55-р байр 2 давхарт 3 тоот
Утас: (+976) 77121286
Вэб хуудас: www.institute.gov.mn

АГУУЛГА

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ	3
ЗУРГИЙН ЖАГСААЛТ	3
ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД	6
Хөдөлмөрийн зах зээлийн үзүүлэлтүүд	6
Нийгмийн даатгалын үзүүлэлтүүд	15
Сарын дундаж цалингийн үзүүлэлтүүд	20
ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ҮЙЛ АЖИЛЛАГАА.....	23
Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ.....	23
Гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах, гадаадад ажиллах хүч зуучлах	27
Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа	28
МОНГОЛ УЛСЫН ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ДУНД ХУГАЦААНЫ ЭРЭЛТ, НИЙЛҮҮЛЭЛТИЙН ТААМАГЛАЛ-2024 ОН	32
Таамаглалын хураангуй.....	32
Ажиллах хүчний таамаглал	32

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Хөдөлмөр эрхлэлтийн үндсэн үзүүлэлтүүд, мянган хүн.....	7
Хүснэгт 2. Ажилгүй хүний тоо, улирлаар, мянган хүн	11
Хүснэгт 3. Нийгмийн даатгалд шимтгэл төлөгч байгууллага, даатгуулагч, улирлаар	15
Хүснэгт 4. Тэтгэврийн даатгалын сангаас тэтгэвэр авсан иргэдийн тоо, төрөл, улирлаар...	17
Хүснэгт 5. Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлага, тэрбум төгрөгөөр	19
Хүснэгт 6. Ажиллагчдын сарын дундаж цалин, хүйсээр, мянган төгрөг	20
Хүснэгт 7. Ажиллагчдын сарын дундаж цалин, ажиллагчдын тооны бүлэг, хүйсээр, мянган төгрөг	21
Хүснэгт 8. Ажил хайгч болон бүртгэлтэй ажилгүй иргэн, сарын эцэст, улирлаар	23
Хүснэгт 9. Ажлын байрны захиалга, ажилд зуучлагдсан иргэн, улирлаар	25
Хүснэгт 10. Ажлын байрны захиалга, ажилд зуучлагдсан иргэд	26
Хүснэгт 11. Ажиллах хүчний таамаглал, мянган хүн	32
Хүснэгт 12. Ажилгүй иргэдийн тооны таамаглал, мянган хүн	32
Хүснэгт 13. Ажиллагчдын тооны таамаглал, мянган хүн.....	33
Хүснэгт 14. Хөдөлмөр эрхлэлтийн түвшний таамаглал.....	33
Хүснэгт 15. Шаардлагатай ажиллагчдын тооны таамаглал, мянган хүн	34
Хүснэгт 16. Шаардлагатай ажиллагчдын тоо, салбараар таамаглал, ДНБ-ий таамаглалын холимог трендээр, мянган хүн.....	34
Хүснэгт 17. Шаардлагатай ажиллагчдын тоо, ажил мэргэжлээрх таамаглал, ДНБ-ий таамаглалын холимог трендээр өсөх үед, мянган хүн.....	36

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Ажиллах хүч, ажиллах хүчнээс гадуурх хүн амын тоо, мянган хүн, 2024 оны IV улирал.....	6
Зураг 2. Ажиллагчид, ажилгүй хүний тоо, улирлаар, мянган хүн	7
Зураг 3. Ажиллагчдын тоо, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар, мянган хүн	8
Зураг 4. Ажиллагчдын тооны өөрчлөлт, салбар, өмнөх оны мөн үеэс, мянган хүн.....	9
Зураг 5. Ажиллагчдын тооны өөрчлөлт, эдийн засгийн үйл ажиллагааны үндсэн 3 салбараар, хүйсээр, өмнөх оны мөн үеэс, мянган хүн	9
Зураг 6. Ажиллагчдын тоо, байршлаар, бүсээр	10
Зураг 7. Ажилгүй хүний тоо, өөрчлөлт, өмнөх оны мөн үеэс, мянган хүн	11
Зураг 8. Ажилгүйчүүд, боловсролын түвшнээр, хувиар	12
Зураг 9. Хөдөлмөрийн насны хүн ам (15+), хөдөлмөрийн насны хүн амд ажиллагчдын эзлэх хувь, улирлаар.....	12
Зураг 10. Ажиллах хүчний оролцооны түвшин, хөдөлмөр эрхлэлтийн түвшин.....	13
Зураг 11. Даатгуулагчийн тоо, төрөл, улирлаар	16
Зураг 12. Сайн дураар даатгуулсан малчдын тоо, мянган хүнээр, улирлаар.....	16
Зураг 13. Тэтгэврийн даатгалын сангаас тэтгэвэр авсан иргэд, төрлөөр, хувиар	17
Зураг 14. Тэтгэмжийн даатгалын сангаас тэтгэмж авсан иргэдийн тоо, төрлөөр.....	18
Зураг 15. ҮОМШӨ-ний даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж авсан иргэд, төрлөөр, хувиар ..	18
Зураг 16. Ажилгүйдлийн тэтгэмжид хамрагдсан хүн, зарцуулсан хөрөнгө, улирлаар	19
Зураг 17. Дундаж болон медиан цалин, мянган төгрөг, улирлаар.....	20
Зураг 18. Ажил хайгч болон бүртгэлтэй ажилгүй иргэн, сарын эцэст, улирлаар	24
Зураг 19. Ажил хайгч болон бүртгэлтэй ажилгүй иргэн, боловсролын түвшин, дүнд эзлэх хувиар	24

Зураг 20. Хөдөлмөрийн гэрээгээр ажил эрхэлж буй гадаадын иргэд, хамгийн их 6 улсаар, дүнд эзлэх хувиар	27
Зураг 21. Хөдөлмөрийн гэрээгээр гадаад улсад зуучлагдсан иргэд.....	28
Зураг 22. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд хамрагдсан иргэд, зарцуулсан хөрөнгө, сая төгрөг, 2024 оны IV улирлын байдлаар	29
Зураг 23. Хөдөлмөрт бэлтгэх сургалтын үйл ажиллагаанд хамрагдсан иргэд, зарцуулсан хөрөнгө, 2024 оны IV улирлын байдлаар	29
Зураг 24. Санхүүгийн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаанд хамрагдсан иргэд, зарцуулсан хөрөнгө, 2024 оны IV улирлын байдлаар	30
Зураг 25. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт зарцуулсан хөрөнгө, 2024 оны IV улирлын байдлаар	31
Зураг 26. Түр ажлын байрыг дэмжих хөтөлбөрт хамрагдсан иргэд, зарцуулсан хөрөнгө, 2024 оны IV улирлын байдлаар	31

ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД-2024 ОНЫ IV УЛИРАЛ

2024 оны IV улирлын байдлаар арван тав, түүнээс дээш насны хүн амын **1 428.8** мянга (62.2 хувь) нь ажиллах хүч, **869.2** мянга (37.8хувь) нь ажиллах хүчнээс гадуурх хүн ам байна.

АЖИЛЛАХ ХҮЧ



1 428.8 МЯНГА



94.7%
Ажиллагчид



5.3%
Ажилгүй хүн

АЖИЛЛАХ ХҮЧНЭЭС ГАДУУРХ



869.2 МЯНГА



33.4%
Тэтгэвэрт



35.6%
Суралцдаг



31.0%
Бусад

АЖИЛЛАГЧДЫН ТОО, мянган хүн

2023 IV

54.2%

45.8%

1 322.4

2024 IV

54.6%

45.4%

1 353.4



2.3%

Өмнөх оны мөн үеэс

ХАМГИЙН ИХ АЖИЛЛАГЧИДАЙ 3 САЛБАР



321.3 мянга (23.7%)

Хөдөө аж ахуй, ойн аж ахуй,
загас барилт, ан агнуур

59.7%
191.6 мянга



40.3%
129.6 мянга



190.6 мянга (14.1%)

Бөөний болон жижиглэн худалдаа,
машин, мотоциклийн завсар, үйлчилгээ

44.5%
84.9 мянга



55.5%
105.7 мянга



130.0 мянга (9.6%)

Боловсрол

22.4%
29.1 мянга



77.6%
100.9 мянга

АЖИЛГҮЙ ИРГЭД

2023 IV

64.6%

35.4%

53.3 мянга

2024 IV

58.1%

41.9%

75.4 мянга



41.3%

Өмнөх оны мөн үеэс

Мэдээллийн эх үүсвэр: www.1212.mn



www.institute.gov.mn



(976)-77121286



https.info@institute.gov.mn



<https://www.facebook.com/institute.gov.mn>


ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Хөдөлмөрийн зах зээлийн үзүүлэлтүүд

Үндэсний статистикийн хорооны Ажиллах хүчний судалгааны 2024 оны IV улирлын дүнгээс харахад арван тав, түүнээс дээш насны хүн 2,298.0 мянга, үүнээс 1,428.8 мянга (62.2 хувь) нь ажиллах хүч, 869.2 мянга (37.8 хувь) нь ажиллах хүчнээс гадуурх хүн ам байна. Хөдөлмөрийн насны хүн ам өмнөх оны мөн үеэс 25.5 мянга буюу 1.1 хувиар өссөн бол өмнөх улиралтай харьцуулахад өөрчлөлт ороогүй байна.

Нийт ажиллах хүчний 54.8 хувь нь эрэгтэйчүүд, 45.2 хувь нь эмэгтэйчүүд байна. Харин ажиллах хүчнээс гадуурх хүн амын 36.0 хувь нь эрэгтэйчүүд, 64.0 хувь нь эмэгтэйчүүд байна.

Зураг 1. Ажиллах хүч, ажиллах хүчнээс гадуурх хүн амын тоо, мянган хүн, 2024 оны IV улирал



Мэдээллийн эх үүсвэр: www.1212.mn, Үндэсний статистикийн хороо

Ажиллах хүч өмнөх оны мөн үеэс 53.1 мянгаар өсөж, өмнөх улирлаас 19.6 мянгаар буурсан байна.

Ажиллах хүчний 1,353.4 мянга (94.7 хувь) нь ажиллагчид, 75.4 мянга (5.3 хувь) нь ажилгүйчүүд байна. Ажиллагчдын тоо өмнөх оны мөн үеэс 31.0 мянгаар (2.3 хувь) өсөж, өмнөх улирлаас 6.9 мянгаар (0.5 хувь) буурсан бол ажилгүй иргэдийн тоо өмнөх оны мөн үеэс 22.1 мянгаар (41.3 хувь) өсөж, өмнөх улирлаас 12.7 мянгаар (14.4 хувь) буурсан байна.

Ажиллах хүчнээс гадуурх хүн ам өмнөх оны мөн үеэс 27.6 мянга буюу 3.1 хувиар, боломжит ажиллах хүч 42.4 мянга буюу 79.5 хувиар буурсан бол бусад ажиллах хүчнээс гадуурх хүн ам 14.9 мянга буюу 1.8 хувиар өссөн байна.

Хөдөлмөрийн дутуу ашиглалт буюу хөдөлмөр эрхлэлтийн хэрэгцээ хангагдахгүй байгаа хөдөлмөрийн насны хүн ам 2024 оны IV улирлын байдлаар улсын хэмжээнд 88.2 мянга болж өмнөх оны мөн үеэс 24.8 мянгаар (21.9 хувь), өмнөх улирлаас 22.2 мянгаар (20.1 хувь) буурсан байна. Хөдөлмөрийн дутуу ашиглалтыг бүтцээр нь авч үзвэл, 88.2 мянга (85.5 хувь) нь ажилгүй хүн, 10.9 мянга (12.4 хувь) нь боломжит ажиллах хүч, 1.9 мянга (2.1 хувь) нь цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэгч байна.

Цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэгч өмнөх оны мөн үеэс 68.7 хувиар буурсан бол өмнөх улирлаас 8.6 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Хөдөлмөр эрхлэлтийн үндсэн үзүүлэлтүүд, мянган хүн

Үзүүлэлт	2023				2024				Өөрчлөлт	
	I	II	III	IV	I	II	III	IV	он	улирал
Ажиллах хүч	1,341.0	1,355.3	1,400.1	1,375.6	1,404.4	1,429.4	1,448.4	1,428.8	53.2	- 19.6
Үүнээс: эмэгтэй	621.0	619.6	630.2	624.0	642.7	648.6	655.4	646.2	22.2	- 9.2
Ажиллагчид	1,253.9	1,279.1	1,326.2	1,322.4	1,332.6	1,347.1	1,360.3	1,353.4	31.0	- 6.9
Үүнээс: эмэгтэй	587.8	590.0	599.5	605.2	612.4	613.9	619.7	614.6	9.4	- 5.1
Цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэгч	6.2	7.0	7.3	6.3	9.5	7.2	1.7	1.9	- 4.4	0.2
Үүнээс: эмэгтэй	2.9	5.3	5.1	3.7	5.9	4.5	1.3	1.2	- 2.5	- 0.1
Ажилгүй хүн	87.2	76.2	73.9	53.3	71.8	82.3	88.1	75.4	22.1	- 12.7
Үүнээс: эмэгтэй	33.2	29.6	30.7	18.9	30.3	34.7	35.7	31.6	12.7	- 4.1
Ажиллах хүчнээс гадуурх хүн ам	931.0	917.2	872.4	896.9	893.7	868.5	849.6	869.2	- 27.7	19.6
Үүнээс: эмэгтэй	563.1	562.1	562.2	567.8	547.0	541.4	541.3	556.1	- 11.7	14.8
Боломжит ажиллах хүч	32.4	28.0	43.6	53.3	36.3	27.8	20.6	10.9	- 42.4	- 9.7
Үүнээс: эмэгтэй	16.5	15.4	30.2	27.7	16.1	13.8	8.6	6.3	- 21.4	- 2.3
Бусад ажиллах хүчнээс гадуурх хүн ам	898.6	889.1	828.8	843.5	857.4	840.6	829.1	858.3	14.8	29.2
Үүнээс: эмэгтэй	546.6	546.7	532.0	540.0	530.9	527.6	532.7	549.8	9.8	17.1
Хөдөлмөрийн дутуу ашиглалт	125.8	111.2	124.7	112.9	117.6	117.3	110.3	88.2	- 24.8	- 22.2
Үүнээс: эмэгтэй	52.6	50.3	66.0	50.3	52.2	53.0	45.7	39.1	- 11.2	- 6.6

Мэдээллийн эх үүсвэр: www.1212.mn, Үндэсний статистикийн хороо

Ажиллагчдын тоо 2024 оны IV улиралд 1,353.4 мянга болж өмнөх оны мөн үеэс 31.0 мянгаар, өмнөх улирлаас 6.9 мянгаар өссөн байна.

Зураг 2. Ажиллагчид, ажилгүй хүний тоо, улирлаар, мянган хүн

Ажиллагчид




1 353.4 мянга

Ажилгүй хүн



75.4 мянга

Мэдээллийн эх үүсвэр: www.1212.mn, Үндэсний статистикийн хороо

2024 оны IV улиралд ажил хөдөлмөр эрхэлж байгаа 100 хүн тутмын 47 нь (47.4 хувь) хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур, бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар, үйлчилгээ, боловсролын салбарт ажиллаж байна. Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуурын салбар нь хөдөлмөр эрхлэлтийн дөрөвний нэг (23.7 хувь)-ийг бүрдүүлдэг хамгийн том салбар хэвээр байна.

Зураг 3. Ажиллагчдын тоо, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар, мянган хүн




Мэдээллийн эх үүсвэр: www.1212.mn, Үндэсний статистикийн хороо

Өмнөх оны мөн үеэс ажиллагчдын тоо өссөн салбарууд: бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар, үйлчилгээ 19.9 мянгаар, төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал 18.1 мянгаар, барилга 16.1 мянгаар, цахилгаан, хий, уур, агааржуулалт 7.7 мянгаар, зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ 6.4 мянгаар, мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа 5.2 мянгаар, боловсрол 4.9 мянгаар, мэдээлэл холбоо 3.2 мянгаар, санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа 3.1 мянгаар, үйлчилгээний бусад үйл ажиллагаа 3.1 мянгаар, урлаг, үзвэр, тоглоом, наадам 3.0 мянгаар, үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа 2.0 мянгаар, тээвэр ба агуулахын үйл ажиллагаа 1.1 мянгаар, удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа 0.5 мянгаар тус тус нэмэгджээ.

Харин өмнөх оны мөн үеэс ажиллагчдын тоо буурсан салбарууд: хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт 27.1 мянгаар, боловсруулах үйлдвэрлэл 20.1 мянгаар, уул уурхай олборлолт 11.4 мянгаар, хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа 3.5 мянгаар, хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа 0.6 мянгаар, олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа 0.5 мянгаар усан хангамж, бохир ус зайлуулах систем, хог хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа 0.2 мянгаар тус бүр буурсан байна.


Зураг 4. Ажиллагчдын тооны өөрчлөлт, салбар, өмнөх оны мөн үеэс, мянган хүн



Мэдээллийн эх үүсвэр: www.1212.mn, Үндэсний статистикийн хороо

Ажиллагчдын тоог хүйсээр харвал өмнөх оны мөн үеэс хөдөө аж ахуйн салбарын эрэгтэй ажиллагчдын тоо 5.6 мянгаар, эмэгтэй ажиллагчдын тоо 21.5 мянгаар буурсан байна. Үйлдвэрлэлийн салбарт эрэгтэй ажиллагчдын тоо өмнөх оны мөн үеэс 0.5 мянгаар өсөж, эмэгтэй ажиллагчдын тоо 8.4 мянгаар буурсан байна. Харин үйлчилгээний салбарт эмэгтэй ажиллагчдын тоо 39.3 мянгаар, эрэгтэй ажиллагчдын тоо 26.7 мянгаар өссөн байна.


Зураг 5. Ажиллагчдын тооны өөрчлөлт, эдийн засгийн үйл ажиллагааны үндсэн 3 салбараар, хүйсээр, өмнөх оны мөн үеэс, мянган хүн



Мэдээллийн эх үүсвэр: www.1212.mn, Үндэсний статистикийн хороо

Ажиллагчдын 606.5 мянга (44.8 хувь) нь Улаанбаатар хотод, 746.8 мянга (55.2 хувь) нь хөдөө, орон нутагт байна. Ажиллагчдыг бүсээр авч үзвэл 261.3 мянга (19.3 хувь) нь Хангайн бүсэд, 203.1 мянга (15.0 хувь) нь Төвийн бүсэд, 181.3 мянга (13.4 хувь) нь Баруун бүсэд, 101.2 мянга (7.5 хувь) нь Зүүн бүсэд байна. Ажиллагчдын тооны өөрчлөлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад Улаанбаатар хот 39.2 мянгаар (6.9 хувь), Хангайн бүс 2.9 мянгаар (1.1 хувь), Зүүн бүс 2.2 мянгаар (2.2 хувь) өссөн бол Төвийн бүс 10.5 мянгаар (4.9 хувь), Баруун бүс 2.8 мянгаар (1.5 хувь) буурсан байна.

Зураг 6. Ажиллагчдын тоо, байршлаар, бүсээр



Мэдээллийн эх үүсвэр: www.1212.mn, Үндэсний статистикийн хороо


2024 оны IV улирлын байдлаар ажилгүй иргэдийн 43.8 мянга (58.1 хувь) нь эрэгтэй, 31.6 мянга (41.9 хувь) нь эмэгтэйчүүд байна.

Ажилгүй иргэдийн тоо өмнөх оны мөн үеэс 22.1 мянга буюу 41.3 хувиар өсжээ. Үүнд ажилгүй эрэгтэйчүүд 9.3 мянга буюу 27.1 хувиар, эмэгтэйчүүд 12.7 мянга буюу 67.3 хувиар өссөн байна.

Ажилгүйчүүдийн тоог бүсээр авч үзвэл Улаанбаатар хотод хамгийн өндөр буюу 47.7 хувь нь, Баруун бүсэд 17.6 хувь нь, Төвийн бүсэд 16.6 хувь нь, Хангайн бүсэд 11.7 хувь нь, Зүүн бүсэд 6.4 хувь нь байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад Улаанбаатар 16.7 мянгаар, Баруун бүс 6.6 мянгаар, Төвийн бүс 2.3 мянгаар, Зүүн бүс 1.1 мянгаар өссөн бол Хангайн бүсэд 4.6 мянгаар ажилгүй иргэдийн тоо буурчээ.

Мөн ажилгүйчүүдийн тоог насны бүлгээр авч үзвэл 17.2 мянга (22.8 хувь) нь 15-24 насны, 22.8 мянга (30.3 хувь) нь 25-34 насны, 19.6 мянга (25.9 хувь) нь 35-44 насны, 12.3 мянга (16.4 хувь) нь 45-54 насны, 3.5 мянга (4.6 хувь) нь 55, түүнээс дээш насны хүн байна. Ажилгүйчүүдийн тоо өмнөх оны мөн үетэй харьцуулахад 15-24 насны залуучууд 4.8 мянгаар, 25-34 насны залуучууд 8.6 мянгаар, 35-44 насны иргэд 7.0 мянгаар, 45-54 насны ажилгүй иргэд 2.5 мянгаар өссөн бол, 55 ба түүнээс дээш насны ажилгүй иргэд 0.8 мянгаар буурсан байна.

Зураг 7. Ажилгүй хүний тоо, өөрчлөлт, өмнөх оны мөн үеэс, мянган хүн

Мэдээллийн эх үүсвэр: www.1212.mn, Үндэсний статистикийн хороо


Хүснэгт 2. Ажилгүй хүний тоо, улирлаар, мянган хүн

Үзүүлэлт		2023				2024				Өөрчлөлт	
		I	II	III	IV	I	II	III	IV	Он	Улирал
Бүгд		87.2	76.2	73.9	53.3	71.8	82.3	88.1	75.4	22.1	-12.7
Хүйсээр	Эрэгтэй	53.9	46.6	43.2	34.5	41.4	47.6	35.7	43.8	9.3	8.1
	Эмэгтэй	33.2	29.6	30.7	18.9	30.3	34.7	52.3	31.6	12.7	-20.7
	15-24	14.1	18.4	17.7	12.4	12.2	21.9	21.2	17.2	4.8	-4.0
Насны бүлгээр	25-34	25.3	20.8	20.1	14.2	22.1	21.9	24.8	22.8	8.6	-2.0
	35-44	24.6	20.4	21.3	12.6	21.2	24.7	22.0	19.6	7.0	-2.4
	45-54	18.7	12.8	11	9.8	12.5	9.9	13.4	12.3	2.5	-1.1
	55+	4.5	3.8	3.9	4.3	3.8	3.9	6.7	3.5	-0.8	-3.2
Бүсээр	Баруун бүс	11.6	13.7	11.7	6.7	13.1	12.3	12.1	13.3	6.6	1.2
	Хангайн бүс	20.8	12.5	16.3	13.4	18.1	15.8	13.8	8.8	-4.6	-5.0
	Төвийн бүс	12.3	15.7	15.2	10.3	11.2	10.9	11.7	12.5	2.2	0.8
	Зүүн бүс	3.5	3.1	5.1	3.7	4.4	3.9	5.0	4.8	1.1	-0.2
	Улаанбаатар	39	31.2	25.5	19.3	24.9	39.4	45.4	35.9	16.6	-9.5

Мэдээллийн эх үүсвэр: www.1212.mn, Үндэсний статистикийн хороо

Ажилгүйчүүдийг боловсролын түвшнээр ангилбал 1.0 хувь нь магистр, 24.8 хувь нь дипломын болон бакалаврын дээд, 4.8 хувь нь тусгай мэргэжлийн дунд, 30.2 хувь нь техникийн болон мэргэжлийн, 25.5 хувь нь бүрэн дунд, 9.0 хувь нь суурь, 2.6 хувь нь бага, 2.0 хувь нь боловсролгүй иргэд байна.


Зураг 8. Ажилгүйчүүд, боловсролын түвшнээр, хувиар



Мэдээллийн эх үүсвэр: www.1212.mn, Үндэсний статистикийн хороо

Ажилгүйдлийн түвшин улсын хэмжээнд 5.3 хувь болж, өмнөх улирлаас 0.8 пунктээр буурч, өмнөх оны мөн үеэс 1.4 пунктээр өссөн байна. Энэ хугацаанд эмэгтэйчүүдийн ажилгүйдлийн түвшин 4.9 хувь болж, өмнөх оны мөн үеэс 1.9 пунктээр, эрэгтэйчүүдийн ажилгүйдлийн түвшин 5.6 хувь болж өмнөх оны мөн үеэс 1.0 пунктээр өссөн байна.

Зураг 9. Хөдөлмөрийн насны хүн ам (15+), хөдөлмөрийн насны хүн амд ажиллагчдын эзлэх хувь, улирлаар




Мэдээллийн эх үүсвэр: www.1212.mn, Үндэсний статистикийн хороо

Хөдөлмөрийн насны хүн амд ажиллах хүчний нийлүүлэлтийн эзлэх хувийг илэрхийлэх түвшин бүхий ажиллах хүчний оролцооны түвшинг улирлаар авч үзэхэд 2024 оны IV улиралд 62.2 хувь болж, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.7 пунктээр өссөн бол өмнөх улирлаас 0.8 пунктээр буурсан байна.

Хөдөлмөрийн нөөцөд ажиллагчдын эзлэх хувь буюу хөдөлмөр эрхлэлтийн түвшин 2024 оны IV улирлын байдлаар 58.9 хувь болж, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0.7 пунктээр өссөн бол өмнөх улирлаас 0.3 пунктээр буурсан байна.

Зураг 10. Ажиллах хүчний оролцооны түвшин, хөдөлмөр эрхлэлтийн түвшин



Мэдээллийн эх үүсвэр: www.1212.mn, Үндэсний статистикийн хороо

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД-2024 ОНЫ IV УЛИРАЛ

ШИМТГЭЛ ТӨЛӨГЧ ААНБ



ТЭТГЭВЭР АВАГЧИД



79.6%
Өндөр насны тэтгэвэр



3.9%
Тэжээгчээ алдсаны тэтгэвэр



12.2%
Хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр



4.3%
Цэргийн тэтгэвэр

ШИМТГЭЛИЙН ОРЛОГО



Ажилгүйдэл
3.0%

131.2 тэрбум



ҮОМШӨ*
5.4%

236.2 тэрбум

ДААТГУУЛАГЧ



☑ Даатгуулагчид, төрлөөр

Албан журам

87.1%
1 161.3 мянга



Сайн дур

12.9%
171.3 мянга



САЙН ДУРААР ДААТГУУЛАГЧ



ЗАРЛАГА



Ажилгүйдэл
2.7%

137.0 тэрбум



ҮОМШӨ*
0.9%

46.0 тэрбум

Мэдээллийн эх үүсвэр: НДЕГ



www.institute.gov.mn



(976)-77121286



https://info@institute.gov.mn



<https://www.facebook.com/institute.gov.mn>

Нийгмийн даатгалын үзүүлэлтүүд

2024 оны IV улирлын байдлаар шимтгэл төлөгч байгууллагын тоо 60.7 мянга болж, өмнөх оны мөн үеэс 2.4 мянга буюу 4.2 хувиар өссөн байна.

Мөн 2024 оны IV улирлын байдлаар нийгмийн даатгалд 1,332.6 мянган даатгуулагч даатгуулсан бөгөөд 171.3 мянга (12.9 хувь) нь сайн дурын, 1,161.3 мянга (87.1 хувь) нь албан журмын даатгуулагч байна. Даатгуулагчийн тоо өмнөх оны мөн үеэс 16.6 мянга буюу 1.3 хувиар өссөн байна.


Албан журмын даатгуулагч өмнөх оны мөн үеэс 3.9 мянга буюу 0.3 хувиар, сайн дурын дурын даатгуулагч 12.7 мянга буюу 8.0 хувиар тус тус өссөн дүнтэй байна.

Хүснэгт 3. Нийгмийн даатгалд шимтгэл төлөгч байгууллага, даатгуулагч, улирлаар

Улирал	Шимтгэл төлөгч ААНБ	Даатгуулагч		
		Нийт	Сайн дур	Албан журам
2020 I	42,862	831,943	108,042	723,901
II	46,762	961,692	156,624	805,068
III	47,818	1,051,309	172,892	878,417
IV	49,067	1,156,793	192,090	964,703
2021 I	46,242	845,802	100,956	744,846
II	48,738	962,387	136,141	826,246
III	50,625	1,062,030	147,827	914,203
IV	52,388	1,181,282	161,111	1,020,171
2022 I	48,462	891,825	107,417	784,354
II	51,776	1,029,922	133,167	896,755
III	53,425	1,141,946	146,833	995,113
IV	55,121	1,274,588	162,414	1,112,174
2023 I	51,282	925,215	108,644	816,571
II	54,405	1,061,097	129,881	931,216
III	56,057	1,175,543	142,159	1,033,384
IV	58,209	1,315,989	158,588	1,157,401
2024 I	49,329	860,181	56,135	804,046
II	53,075	927,414	94,686	832,728
III	58,502	1,209,548	153,909	1,055,639
IV	60,657	1,332,595	171,332	1,161,263

Мэдээллийн эх үүсвэр: Нийгмийн даатгалын ерөнхий газар


Зураг 11. Даатгуулагчийн тоо, төрөл, улирлаар



Мэдээллийн эх үүсвэр: Нийгмийн даатгалын ерөнхий газар

Сайн дурын даатгуулагчдын 51.5 мянга (30.1 хувь) нь малчид, үлдсэн 119.8 мянга (69.9 хувь) нь бусад төрлийн даатгуулагч байна. Даатгалд хамрагдсан малчдын тоо өмнөх оны мөн үеэс 32.9 мянга буюу 2.8 дахин өссөн байна.

Зураг 12. Сайн дураар даатгуулсан малчдын тоо, мянган хүнээр, улирлаар



Мэдээллийн эх үүсвэр: Нийгмийн даатгалын ерөнхий газар

Тэтгэврийн даатгалын сангаас тэтгэвэр авсан иргэд 2024 оны IV улирлын байдлаар 505.6 мянга болж, өмнөх оны мөн үеэс 12.6 мянга буюу 2.6 хувиар нэмэгджээ. Тэтгэвэр авсан иргэдийн 79.6 хувь нь өндөр насны тэтгэвэр, 12.2 хувь нь хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр, 3.9 хувь нь тэжээгчээ алдсаны тэтгэвэр, 4.3 хувь цэргийн тэтгэвэр авсан байна.


Өндөр насны тэтгэвэр авсан иргэд 2024 оны IV улирлын байдлаар 402.4 мянга болж, өмнөх оны мөн үеэс 14.0 мянга буюу 3.6 хувиар, цэргийн тэтгэвэр авсан иргэд 21.7 мянга болж 328 буюу 1.5 хувиар өссөн бол тэжээгчээ алдсаны тэтгэвэр авсан иргэд 19.9 мянга болж 19 буюу 0.1 хувиар, хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр авсан иргэд 61.6 мянга болж 1,736 буюу 2.7 хувиар буурсан байна.

Хүснэгт 4. Тэтгэврийн даатгалын сангаас тэтгэвэр авсан иргэдийн тоо, төрөл, улирлаар

Улирал	Тэтгэвэр авагчдын тоо	Үүнээс:			
		Өндөр насны тэтгэвэр	Хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр	Тэжээгчээ алдсаны тэтгэвэр	Цэргийн тэтгэвэр
2020 I	427,247	320,602	67,912	19,853	18,880
II	434,186	327,799	67,663	19,711	19,013
III	439,481	333,026	67,769	19,584	19,102
IV	444,788	338,982	67,018	19,553	19,235
2021 I	449,419	344,287	66,344	19,511	19,277
II	451,845	347,235	65,771	19,377	19,462
III	454,298	350,091	65,197	19,437	19,573
IV	456,365	353,775	63,318	19,563	19,709
2022 I	462,607	359,783	63,439	19,588	19,797
II	467,420	364,173	63,491	19,625	20,131
III	471,387	368,050	63,280	19,705	20,424
IV	476,446	373,209	62,702	19,743	20,792
2023 I	480,312	376,643	63,097	19,744	20,828
II	484,981	380,843	63,133	19,850	21,155
III	488,366	384,043	63,117	19,969	21,237
IV	493,038	388,345	63,305	20,008	21,380
2024 I	496,669	391,819	63,302	20,079	21,469
II	500,560	395,387	63,412	20,107	21,654
III	503,903	399,241	62,902	20,143	21,617
IV	505,624	402,358	61,569	19,989	21,708

Мэдээллийн эх үүсвэр: Нийгмийн даатгалын ерөнхий газар

Зураг 13. Тэтгэврийн даатгалын сангаас тэтгэвэр авсан иргэд, төрлөөр, хувиар




Мэдээллийн эх үүсвэр: Нийгмийн даатгалын ерөнхий газар

Тэтгэмжийн даатгалын сангаас тэтгэмж авсан иргэд 2024 оны IV улирлын байдлаар 156.0 мянга болж, өмнөх оны мөн үеэс 62.3 мянга буюу 28.5 хувиар буурсан байна. Тэтгэмж авсан иргэдийн 57.9 хувь нь хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж, 32.9 хувь нь жирэмсний болон амаржсаны тэтгэмж, 9.2 хувь нь нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмж авсан байна.

Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж авсан иргэд 2024 оны IV улирлын байдлаар 90.3 мянга болж, өмнөх оны мөн үеэс 37.0 хувиар, жирэмсний болон амаржсаны тэтгэмж авсан иргэд 51.4 мянга болж өмнөх оны мөн үеэс 15.1 хувиар буурсан бол нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмж авсан иргэд 14,3 мянга болж, өмнөх оны мөн үеэс 0.9 хувиар өссөн байна.

Зураг 14. Тэтгэмжийн даатгалын сангаас тэтгэмж авсан иргэдийн тоо, төрлөөр

Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж



Жирэмсний болон амаржсаны тэтгэмж




Нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмж



Мэдээллийн эх үүсвэр: Нийгмийн даатгалын ерөнхий газар

Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж авсан иргэд 2024 оны IV улирлын байдлаар 6.7 мянга болж, өмнөх оны мөн үеэс 493 буюу 6.9 хувиар буурсан байна. ҮОМШӨ-ны даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж авсан иргэдийн 51.2 хувь нь хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр, 25.8 хувь нь эрүүл мэндийн нөхөн сэргээлтийн зардлын төлбөр, 16.6 хувь нь тэтгэмж, төлбөр, 6.4 хувь нь тэжээгчээ алдсаны тэтгэвэрт хамрагдсан байна.

Зураг 15. ҮОМШӨ-ний даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж авсан иргэд, төрлөөр, хувиар



Мэдээллийн эх үүсвэр: Нийгмийн даатгалын ерөнхий газар

Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого 2024 оны IV улирлын байдлаар 4,369.7 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 889.5 тэрбум төгрөг буюу 25.6 хувиар, нийгмийн даатгалын зарлага 5,095.0 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 1,118.8 тэрбум төгрөг буюу 28.1 хувиар нэмэгдсэн.

2024 оны IV улирлын байдлаар шимтгэлийн орлогын 82.9 хувийг тэтгэврийн даатгалын сан, 8.7 хувийг тэтгэмжийн даатгалын сан, 5.4 хувийг үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сан, 3.0 хувийг ажилгүйдлийн даатгалын сангийн орлого бүрдүүлж байна. Харин нийгмийн даатгалын зарлагын 91.3 хувийг тэтгэврийн даатгалын сан, 5.1 хувийг тэтгэмжийн даатгал сан, 0.9 хувийг үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сан, 2.7 хувийг ажилгүйдлийн даатгалын сангийн зарлага эзэлж байна.

Хүснэгт 5. Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлага, тэрбум төгрөгөөр

Үзүүлэлт	2023 IV	Эзлэх хувь		2024 IV	Өөрчлөлт	
					Тоо	Хувь
НД-ын сангийн орлого	3,480.2	100.0%	4,369.7	100.0%	889.5	25.6%
Тэтгэвэр	2,862.0	82.2%	3,621.0	82.9%	759.0	26.5%
Тэтгэмж	299.3	8.6%	381.2	8.7%	81.9	27.4%
ҮОМШӨ	260.3	7.5%	236.2	5.4%	-24.1	-9.3%
Ажилгүйдэл	58.6	1.7%	131.2	3.0%	72.6	123.9%
НД-ын сангийн зарлага	3,976.1	100.0%	5,095.0	100.0%	1,118.9	28.1%
Тэтгэвэр	3,615.3	90.9%	4,653.6	91.3%	1,038.0	28.7%
Тэтгэмж	212.0	5.3%	258.3	5.1%	46.3	21.8%
ҮОМШӨ	38.6	0.9%	46.0	0.9%	7.4	19.2%
Ажилгүйдэл	110.2	2.7%	137.0	2.7%	26.8	24.3%

Мэдээллийн эх үүсвэр: Нийгмийн даатгалын ерөнхий газар

Ажилгүйдлийн тэтгэмжид 2024 оны IV улирлын байдлаар 30.8 мянган иргэн хамрагдсан бөгөөд тэтгэмж болгож 137.0 тэрбум төгрөгийг зарцуулсан байна. Ажилгүйдлийн тэтгэмжид хамрагдсан иргэд өмнөх оны мөн үеэс 0.9 мянга буюу 3.0 хувиар, тэтгэмжид зарцуулсан хөрөнгө 26.8 тэрбум төгрөг буюу 24.4 хувиар нэмэгджээ.

2023 оны IV улиралд ажилгүйдлийн тэтгэмжид хамрагдсан нэг хүнд дунджаар 3.7 сая төгрөгийг зарцуулж байсан бол 2024 оны IV улиралд 4.4 сая болж, 20.7 хувиар нэмэгдсэн байна.

Зураг 16. Ажилгүйдлийн тэтгэмжид хамрагдсан хүн, зарцуулсан хөрөнгө, улирлаар



Мэдээллийн эх үүсвэр: Нийгмийн даатгалын ерөнхий газар

Сарын дундаж цалингийн үзүүлэлтүүд

Аж ахуй нэгж байгууллагын ажиллагчдын сарын дундаж цалин 2024 оны IV улирлын байдлаар 2,672.0 мянга болж, өмнөх оны мөн үеэс 436.6 мянга буюу 19.5 хувиар, өмнөх улирлаас 192.4 мянга буюу 7.8 хувиар өссөн байна. Тухайн өсөлт нь нэрлэсэн дундаж цалингийн өсөлт бөгөөд бодит цалинийн өсөлт биш юм.

Ажиллагчдын сарын дундаж цалинг хүйсээр авч үзвэл, эрэгтэйчүүд 2,923.3 мянган төгрөг, эмэгтэйчүүд 2,410.6 мянган төгрөгийн цалинтай байна. Эрэгтэй, эмэгтэйчүүдийн цалингийн зөрүү 2024 оны IV улиралд 512.7 мянган төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 12.0 мянгаар өссөн байна.

Өөрөөр хэлбэл 2024 оны IV улирлын байдлаар эмэгтэйчүүдийн дундаж цалин эрэгтэйчүүдийн дундаж цалингийн 82.5 хувьтай тэнцэж байгаа бөгөөд өмнөх оны мөн үеэс 2.7 пунктээр буурсан байна.

Хүснэгт 6. Ажиллагчдын сарын дундаж цалин, хүйсээр, мянган төгрөг

Үзүүлэлт	2023				2024				Өөрчлөлт	
	I	II	III	IV	I	II	III	IV	Он	Улирал
Дундаж цалин	1,830.8	1,890.0	2,009.3	2,235.4	2,283.7	2,464.9	2,479.6	2,672.0	436.6	192.4
Эрэгтэй	2,044.2	2,096.4	2,275.4	2,479.8	2,568.4	2,716.7	2,766.0	2,923.3	443.5	157.3
Эмэгтэй	1,610.9	1,675.6	1,737.9	1,979.1	1,987.8	2,200.0	2,185.4	2,410.6	431.5	225.2

Мэдээллийн эх үүсвэр: www.1212.mn, Үндэсний статистикийн хороо

Медиан цалин гэдэг ажиллагчдын цалинг өсөх эсвэл буурах эрэмбээр байршуулсан цувааг таллан хувааж байгаа ажилтны цалин юм. 2024 оны IV улирлын байдлаар медиан цалин 2,229.4 мянган төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 448.0 мянган төгрөгөөр буюу 25.1 хувиар, өмнөх улирлаас 205.1 мянган төгрөгөөр буюу 10.1 хувиар өссөн байна.

2024 оны IV улирлын байдлаар нийгмийн даатгалд шимтгэл төлсөн ажиллагчдыг цалин хөлсний бүлгээр авч үзвэл 420.0 мянгаас 700.0 мянган төгрөгийн цалинтай 11.0 хувь, харин 2.0 сая болон түүнээс дээш төгрөгийн цалинтай ажиллагчдын эзлэх хувь 55.9 хувь байна.

Зураг 17. Дундаж болон медиан цалин, мянган төгрөг, улирлаар



Мэдээллийн эх үүсвэр: www.1212.mn, Үндэсний статистикийн хороо

2024 оны IV улирлын байдлаар 1-9 ажиллагчидтай байгууллагын дундаж цалин улсын дунджаас 1,146.3 мянгаар, 10-49 ажиллагчидтай байгууллагынх 385.6 мянгаар, 50-99 ажиллагчидтай байгууллагынх 31.2 мянгаар бага байгаа бол 100-199 ажиллагчидтай байгууллагынх 157.8 мянгаар, 200 түүнээс дээш ажиллагчидтай байгууллагынх 835.8 мянган төгрөгөөр өндөр байна.

Дундаж цалингийн өөрчлөлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулж үзэхэд 50-99 ажиллагчидтай байгууллагын ажиллагчдын дундаж цалин хамгийн их буюу 491.3 мянган төгрөг (22.9 хувиар)-өөр нэмэгдсэн байна.

Хүснэгт 7. Ажиллагчдын сарын дундаж цалин, ажиллагчдын тооны бүлэг, хүйсээр, мянган төгрөг

Ажиллагчдын тооны бүлэг	2023 IV			2024 IV			Өөрчлөлт	
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Тоо	Хувь
Бүгд	2,235.4	2,479.8	1,979.1	2,672.0	2,923.3	2,410.6	436.6	19.5%
1-9	1,242.1	1,239.6	1,244.6	1,525.7	1,523.1	1,528.2	283.6	22.8%
10-49	1,845.7	1,858.3	1,834.6	2,286.4	2,287.8	2,285.3	440.7	23.9%
50-99	2,149.5	2,278.6	2,032.7	2,640.8	2,767.4	2,533.8	491.3	22.9%
100-199	2,355.5	2,520.9	2,181.5	2,829.8	2,998.9	2,661.6	474.3	20.1%
200 дээш	3,042.2	3,502.0	2,415.8	3,507.8	3,974.9	2,851.7	465.6	15.3%

Мэдээллийн эх үүсвэр: www.1212.mn, Үндэсний статистикийн хороо

Ажиллагчдын сарын дундаж цалинг эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангиллаар авч үзэхэд уул уурхай, олборлолтын салбарт ажиллагчдын цалин хамгийн их буюу 5.4 сая төгрөг, зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээний салбарт хамгийн бага буюу 1.7 сая төгрөг байна.

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭ-2024 ОНЫ IV УЛИРАЛ

АЖИЛ ХАЙГЧ ИРГЭН



11 970



50.0%
Эмэгтэй



2.1%
Хөгжлийн
бэрхшээлтэй

БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭН



9 996



50.9%
Эмэгтэй



2.0%
Хөгжлийн
бэрхшээлтэй

АЖЛЫН БАЙРНЫ ЗАХИАЛГА



112 390



29.8%
Эрэлт хангасан хувь

↑ 32.4%
Өмнөх оны
мөн үеэс

АЖИЛД ЗУУЧЛАГДСАН ИРГЭН



33 485



50.1%
Эмэгтэй

↓ 5.1%
Өмнөх оны мөн үеэс

Мэдээллийн эх үүсвэр: ХХҮЕГ

ХӨДӨЛМӨРИЙН ГЭРЭЭГЭЭР АЖИЛ ЭРХЭЛЖ БҮЙ ГАДААДЫН ИРГЭД, улсаар

8 024

Гадаадын иргэд

=




6 779 (84.5%)
Эрэгтэй

+



1 245 (15.5%)
Эмэгтэй



Мэдээллийн эх үүсвэр: www.1212.mn



www.institute.gov.mn



(976)-77121286



https:info@institute.gov.mn



<https://www.facebook.com/institute.gov.mn>

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ

Ажилгүй эсхүл ажилтай боловч ажлын нөхцөлөө сайжруулах, нэмэлт орлого олох зорилгоор ажил хайж байгаа иргэдийн тоо 2024 оны IV улирлын байдлаар 12.0 мянга (үүний 6.0 мянга буюу 50.0 хувь нь эмэгтэй) байна. Насны бүлгээр авч үзвэл, 1.8 мянга (14.7 хувь) нь 15-24 насны, 3.8 мянга (32.0 хувь) нь 25-34 насны, 3.5 мянга (29.5 хувь) нь 35-44 насны, 2.1 мянга (17.9 хувь) нь 45-54 насны, 0.7 мянга (5.9 хувь) нь 55, түүнээс дээш насныхан байна.

Харин тухайн үед ажилгүй байгаа, ажил идэвхтэй хайж хөдөлмөр халамжийн үйлчилгээний хэлтэс, хөдөлмөрийн хувийн биржид бүртгүүлсэн бүртгэлтэй ажилгүй иргэн 10.0 мянга байна. Бүртгэлтэй ажилгүй иргэдийн 4.9 мянга (49.1 хувь) нь эрэгтэйчүүд, 5.1 мянга (50.9 хувь) нь эмэгтэйчүүд байна. Насны бүлгээр авч үзвэл, 1.5 мянга (14.6 хувь) нь 15-24 насны, 3.3 мянга (32.8 хувь) нь 25-34 насны, 2.9 мянга (29.4 хувь) нь 35-44 насны, 1.8 мянга (17.6 хувь) нь 45-54 насны, 0.5 мянга (5.6 хувь) нь 55, түүнээс дээш насныхан байна.

Хүснэгт 8. Ажил хайгч болон бүртгэлтэй ажилгүй иргэн, сарын эцэст, улирлаар

Улирал	Ажил хайгч			Бүртгэлтэй ажилгүй иргэн		
	/сарын эцэст/	Эмэгтэй	Эзлэх хувь	/сарын эцэст/	Эмэгтэй	Эзлэх хувь
2020 I	31,785	16,285	51.2%	19,394	10,009	51.6%
II	30,320	15,367	50.7%	19,563	10,001	51.1%
III	27,504	14,301	52.0%	17,829	9,446	53.0%
IV	29,952	15,390	51.4%	18,103	9,535	52.7%
2021 I	25,105	12,774	50.9%	16,775	8,650	51.6%
II	26,991	13,837	51.3%	17,650	9,202	52.1%
III	21,804	11,316	51.9%	15,053	7,895	52.4%
IV	27,950	14,510	51.9%	18,644	9,821	52.7%
2022 I	24,255	12,019	49.6%	16,622	8,345	50.2%
II	24,184	12,075	49.9%	16,282	8,210	50.4%
III	19,832	10,609	53.5%	13,545	7,389	54.8%
IV	21,256	11,069	52.1%	13,966	7,326	52.4%
2023 I	14,246	7,238	50.7%	9,069	4,651	51.1%
II	5,737	2,954	51.5%	4,323	2,265	52.4%
III	6,224	3,372	54.2%	4,655	2,568	55.2%
IV	11,662	6,308	54.1%	8,813	4,784	54.3%
2024 I	6,896	3,303	47.9%	5,494	2,590	47.1%
II	9,563	4,384	45.8%	7,681	3,570	46.5%
III	7,178	3,579	49.9%	5,811	2,954	50.8%
IV	11,970	5,984	50.0%	9,996	5,091	50.9%

Мэдээллийн эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газар

Зураг 18. Ажил хайгч болон бүртгэлтэй ажилгүй иргэн, сарын эцэст, улирлаар



Мэдээллийн эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газар

Ажил хайгч иргэдийн боловсролын түвшинг авч үзвэл, 1.1 хувь нь боловсролгүй, 4.0 хувь нь бага, 8.8 хувь нь суурь, 45.0 хувь нь бүрэн дунд, 7.5 хувь нь техникийн болон мэргэжлийн, 4.4 хувь нь тусгай мэргэжлийн дунд, 27.4 дипломын дээд болон бакалавр, 1.8 хувь нь магистр, түүнээс дээш түвшний боловсролтой байна.

Бүртгэлтэй ажилгүй иргэдийг боловсролын түвшнээр авч үзвэл, 1.1 хувь нь боловсролгүй, 4.2 хувь нь бага, 8.2 хувь нь суурь, 44.2 хувь нь бүрэн дунд, 7.6 хувь нь техникийн болон мэргэжлийн, 4.6 хувь нь тусгай мэргэжлийн дунд, 28.2 хувь нь дипломын дээд болон бакалавр, 1.9 хувь нь магистр, түүнээс дээш түвшний боловсролтой байна.

Зураг 19. Ажил хайгч болон бүртгэлтэй ажилгүй иргэн, боловсролын түвшин, дүнд эзлэх хувиар



Мэдээллийн эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газар

2024 оны IV улиралд 112.4 мянган ажлын байрны захиалга ирсэн бөгөөд 33.5 мянган иргэнийг ажилд зуучилж, эрэлтийн 29.8 хувийг хангажээ. Ажлын байрны захиалга өмнөх оны мөн үеэс 27.5 мянга буюу 32.4 хувиар өсөж, ажилд зуучлагдсан иргэд өмнөх оны мөн үеэс 1.8 мянга буюу 5.1 хувиар буурсан байна.

Ажилд зуучлагдсан иргэдийг насны бүлгээр авч үзвэл, 5.3 мянга (15.9 хувь) нь 15-24 насны, 9.3 мянга (27.6 хувь) нь 25-34 насны, 8.8 мянга (26.2 хувь) нь 35-44 насны, 6.2 мянга (18.6 хувь) нь 45-54 насны, 3.9 мянга (11.7 хувь) нь 55, түүнээс дээш насныхан байна.

2024 оны IV улиралд хөдөлмөрийн эрэлтийн 29.8 хувийг хангасан бөгөөд өмнөх оны мөн үеэс 11.8 пунктээр буурч, өмнөх улирлаас 4.7 пунктээр өссөн байна.

Хүснэгт 9. Ажлын байрны захиалга, ажилд зуучлагдсан иргэн, улирлаар

Улирал	Ажлын байрны захиалга	Ажилд зуучлагдсан иргэн	Эмэгтэй	Эзлэх хувь	Эрэлт хангасан хувь
2020 I	7,595	4,489	2,307	51.4%	59.1%
II	28,036	15,250	7,330	48.1%	54.4%
III	42,433	21,672	10,858	50.1%	51.1%
IV	58,022	33,006	16,651	50.4%	56.9%
2021 I	6,413	3,066	1,545	50.4%	47.8%
II	20,352	11,416	5,542	48.5%	56.1%
III	32,656	17,636	9,068	51.4%	54.0%
IV	51,034	29,929	15,460	51.7%	58.6%
2022 I	9,322	3,901	2,003	51.3%	41.8%
II	24,320	13,670	6,709	49.1%	56.2%
III	32,972	18,897	9,499	50.3%	57.3%
IV	55,211	32,290	16,412	50.8%	58.5%
2023 I	4,863	2,267	1,066	47.0%	46.6%
II	16,950	8,199	4,149	50.6%	48.3%
III	50,222	16,656	8,660	51.2%	33.2%
IV	84,870	35,281	18,903	53.6%	41.6%
2024 I	17,435	4,930	2,486	50.4%	28.3%
II	53,198	13,964	6,521	46.7%	26.2%
III	73,959	18,564	8,976	48.4%	25.1%
IV	112,390	33,485	16,763	50.1%	29.8%

Мэдээллийн эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газар

Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийг эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар авч үзвэл, 2024 оны IV улиралд ирсэн ажлын байрны захиалгын 16.6 мянга нь хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур (14.8 хувь), 16.5 мянга нь боловсруулах үйлдвэрлэл (14.7 хувь), 13.8 мянга нь уул уурхай, олборлолт (12.3 хувь)-ын салбараас ирсэн байна.

2024 оны IV улирлын байдлаар боловсрол, цахилгаан, хий, уур, агааржуулалт, төрийн удирдлага, батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал, хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур, мэдээлэл, холбоо, хүний эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйл ажиллагаа, санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа, хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа, үйлчилгээний бусад үйл ажиллагаа, бөөний болон жижиглэн худалдаа; машин, мотоциклийн засвар, үйлчилгээний салбарын эрэлтийн 53.7-30.8

хувийг, ус хангамж, бохир ус зайлуулах систем, хог хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа, урлаг, үзвэр, тоглоом наадам, тээвэр, агуулахын үйл ажиллагаа, зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ, боловсруулах үйлдвэрлэл, удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа, уул уурхай, олборлолтын салбарын эрэлтийн 29.6-21.9 хувийг хангасан байна.

Хүснэгт 10. Ажлын байрны захиалга, ажилд зуучлагдсан иргэд

Үзүүлэлт	Ажлын байрны захиалга	Эзлэх хувь	Ажилд зуучлагдсан иргэн	Эзлэх хувь	Эрэлт хангасан хувь
Бүгд	112,390	100.00%	33,485	100.00%	29.8%
ХАА, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	16,599	14.8%	6,561	19.6%	39.5%
Уул уурхай, олборлолт	13,804	12.3%	3,027	9.0%	21.9%
Боловсруулах үйлдвэрлэл	16,549	14.7%	4,261	12.7%	25.7%
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	441	0.4%	226	0.7%	51.2%
Ус хангамж, бохир ус зайлуулах систем, хог хаягдал	8,954	8.0%	2,647	7.9%	29.6%
Барилга	11,516	10.2%	1,269	3.8%	11.0%
Бөөний болон жижиглэн худалдаа	8,240	7.3%	2,539	7.6%	30.8%
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	3,006	2.7%	806	2.4%	26.8%
Зочид буудал, байр, нийтийн хоолны үйлчилгээ	3,558	3.2%	941	2.8%	26.4%
Мэдээлэл, холбоо	586	0.5%	221	0.7%	37.7%
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	582	0.5%	214	0.6%	36.8%
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	36	0.0%	4	0.0%	11.1%
Мэргэжлийн ШУ болон техникийн үйл ажиллагаа	831	0.7%	273	0.8%	32.9%
Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	6,311	5.6%	1,408	4.2%	22.3%
Төрийн удирдлага ба батлан хамгаалах	8,556	7.6%	3,528	10.5%	41.2%
Боловсрол	6,121	5.4%	3,285	9.8%	53.7%
Хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа	3,115	2.8%	1,165	3.5%	37.4%
Урлаг, үзвэр, тоглоом наадам	541	0.5%	155	0.5%	28.7%
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	2,759	2.5%	870	2.6%	31.5%
Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа	247	0.2%	83	0.2%	33.6%
ОУ-ын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа	38	0.03%	2	0.01%	5.3%


Мэдээллийн эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газар

Гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах, гадаадад ажиллах хүч зуучлах

2024 оны IV улирлын байдлаар хөдөлмөрийн гэрээгээр гадаадын 104 улсын 8,024 иргэн ажил, хөдөлмөр эрхэлж байна. Хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа гадаадын иргэд өмнөх оны мөн үеэс 1,542 буюу 23.8 хувиар өссөн бол өмнөх улирлаас 9,807 буюу 55.0 хувиар буурсан байна. Гэрээгээр ажил эрхэлж байгаа гадаадын иргэдийн 6,779 (84.5 хувь) нь эрэгтэйчүүд, 1,245 (15.5 хувь) нь эмэгтэйчүүд байна. Хөдөлмөрийн гэрээгээр ажил эрхэлж буй гадаадын иргэдийн 44.3 хувь нь Улаанбаатар хотод, 37.4 хувь нь Төвийн бүсэд, 12.5 хувь нь Зүүн бүсэд, 3.3 хувь нь Баруун бүсэд, 2.5 хувь нь Хангайн бүсэд оршин сууж байна.

Мөн хөдөлмөрийн гэрээгээр ажил эрхэлж буй гадаадын иргэдийг иргэншлээр нь авч үзвэл, 4,635 (57.8 хувь) нь Хятад, 612 (7.6 хувь) нь Вьетнам, 442 (5.5 хувь) нь Филиппин, 312 (3.9 хувь) нь ОХУ, 260 (3.2 хувь) нь АНУ, 226 (3.2 хувь) нь Өмнөд Солонгос, 235 (2.9 хувь) нь Энэтхэг, үлдсэн 1,268 (15.8 хувь) нь бусад улсын иргэн байна.

Зураг 20. Хөдөлмөрийн гэрээгээр ажил эрхэлж буй гадаадын иргэд, хамгийн их 6 улсаар, дүнд эзлэх хувиар




Мэдээллийн эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газар

2024 оны IV улирлын байдлаар 167 иргэн хөдөлмөрийн гэрээгээр гадаадад ажилд зуучлагдсан бөгөөд өмнөх улирлаас 31 буюу 22.8 хувиар өссөн байна.

Гадаадад ажилд зуучлагдсан иргэдийн 128 (76.7 хувь) нь Өмнөд Солонгос, 39 (23.3 хувь) нь Япон улсад зуучлагдсан. Ажилд зуучлагдсан иргэдийн 98 (58.7 хувь) нь эрэгтэйчүүд, 69 (41.3 хувь) нь эмэгтэйчүүд байна. Хөдөлмөрийн гэрээгээр гадаадад ажилд зуучлагдсан иргэдийг насны бүлгээр нь авч үзвэл, 1.2 хувь нь 20 хүртэлх насны, 8.4 хувь нь 20-24 насны, 29.9 хувь нь 25-29 насны, 26.3 хувь нь 30-34 насны, 26.3 хувь нь 35-39 насны, 7.2 хувь нь 40-44 насны, үлдсэн 0.6 хувь нь 50-54 насныхан байна.

Хөдөлмөрийн гэрээгээр гадаадад зуучлагдсан иргэдийг боловсролын түвшнээр нь авч үзвэл, 61.1 хувь нь бүрэн дунд, 30.5 хувь нь бакалавр, 6.0 хувь нь тусгай мэргэжлийн дунд, 1.2 хувь нь боловсролгүй, 0.6 хувь нь магистр, доктор, 0.6 хувь нь бага боловсролтой байна.

Зураг 21. Хөдөлмөрийн гэрээгээр гадаад улсад зуучлагдсан иргэд



Мэдээллийн эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газар

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа


Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын хэрэгжилтийг хангах хүрээнд ажилгүй иргэн, ажил олоход хүндрэлтэй иргэн, ажил олгогч, залуучууд, эмэгтэйчүүд, малчид, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, ахмад настан зэрэг хөдөлмөрийн зах зээл дэх хүн амын бүлгүүдийн онцлог хэрэгцээнд нийцүүлэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээ, төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлж байна. Энэ хүрээнд 2024 онд улсын хэмжээнд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үндсэн 4 үйл ажиллагаа, 25 арга хэмжээг хэрэгжүүлж байна.

2024 оны IV улирлын байдлаар хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд 53.4 мянган иргэнийг хамруулж, 67.1 тэрбум төгрөгийг зарцуулсан байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд хамрагдсан иргэдийг үйл ажиллагааны төрлөөр авч үзвэл 43.8 хувь нь Хөдөлмөрт бэлтгэх сургалтын үйл ажиллагаа, 33.7 хувь нь Түр ажлын байрыг дэмжих үйл ажиллагаа, 13.9 хувь нь Санхүүгийн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа, 8.6 хувь нь Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд хамрагдсан байна.

Зарцуулсан хөрөнгийг үйл ажиллагааны төрлөөр авч үзвэл 73.3 хувь нь Санхүүгийн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа, 14.4 хувь нь Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа, 10.2 хувь нь Түр ажлын байрыг дэмжих үйл ажиллагаа, 2.1 хувь нь Хөдөлмөрт бэлтгэх сургалтын үйл ажиллагаанд зарцуулсан байна.

Зураг 22. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд хамрагдсан иргэд, зарцуулсан хөрөнгө, сая төгрөг, 2024 оны IV улирлын байдлаар



Мэдээллийн эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газар

Хөдөлмөрт бэлтгэх сургалтын үйл ажиллагаанд 2024 оны IV улирлын байдлаар 23.4 мянган иргэн хамрагдаж, 1,407.8 сая төгрөг зарцуулсан байна.

Хөдөлмөрт бэлтгэх сургалтын үйл ажиллагаанд хамрагдсан иргэдийн 37.8 хувь нь аж ахуй эрхлэлтийн сургалт, 30.1 хувь нь суурь ур чадварын сургалт, 14.9 хувь нь танхимын болон үйлдвэрлэл дээрх сургалт, 13.2 хувь нь залуучуудын сургалтын зөвлөгөө, 4.0 хувь нь эмэгтэйчүүдэд зориулсан богино хугацааны ур чадварын сургалтад хамрагдсан байна. Харин зарцуулсан хөрөнгийн 50.3 хувь нь танхимын болон үйлдвэрлэл дээрх сургалт, 14.5 хувь нь аж ахуй эрхлэлтийн сургалт, 14.1 хувь нь суурь ур чадварын сургалт, 12.3 хувь нь эмэгтэйчүүдэд зориулсан богино хугацааны ур чадварын сургалт, 8.7 хувь нь залуучуудын сургалт, зөвлөгөө зохион байгуулах арга хэмжээнд зарцуулсан байна.

Зураг 23. Хөдөлмөрт бэлтгэх сургалтын үйл ажиллагаанд хамрагдсан иргэд, зарцуулсан хөрөнгө, 2024 оны IV улирлын байдлаар




Мэдээллийн эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газар

Санхүүгийн дэмжлэг олгох хөтөлбөрт 2024 оны IV улирлын байдлаар 7.5 мянган иргэн хамрагдаж, 49,203.0 сая төгрөг зарцуулсан байна.

Санхүүгийн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаанд хамрагдсан иргэдийн 44.6 хувь нь малчдыг малжуулах үйл ажиллагаанд, 21.1 хувь нь иргэн, аж ахуй эрхлэгчид санхүүгийн дэмжлэг, 19.0 хувь нь ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санхүүгийн дэмжлэг, 13.4 хувь нь түрээсийн болон борлуулалтын дэмжлэг үзүүлэх, үлдсэн 1.9 хувь бусад арга хэмжээнд хамрагдсан байна. Харин зарцуулсан хөрөнгийн 53.7 хувь нь малчдыг малжуулах арга хэмжээ, 25.6 хувь нь иргэн, аж ахуй нэгжийн санхүүгийн дэмжлэг, 17.6 хувь нь ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санхүүгийн дэмжлэг, үлдсэн 3.1 хувь нь бусад үйл ажиллагаанд зарцуулагдсан байна.

Зураг 24. Санхүүгийн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаанд хамрагдсан иргэд, зарцуулсан хөрөнгө, 2024 оны IV улирлын байдлаар



Мэдээллийн эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газар

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт 2024 оны IV улирлын байдлаар 4.6 мянган иргэн хамрагдаж, 9,687.0 сая төгрөгийг зарцуулсан байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд хамрагдсан иргэдийн 65.2 хувь нь санхүүгийн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа, 16.4 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бусад үйл ажиллагаа, 11.1 хувь нь хөдөлмөр эрхлэлтийн сургалт, 7.3 хувь нь бусад үйл ажиллагаанд хамрагдсан байна. Харин зарцуулсан хөрөнгийн 63.3 хувь нь санхүүгийн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа, 28.9 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бусад үйл ажиллагаа, 2.5 хувь нь ажил олгогчийг дэмжих үйл ажиллагаа, 3.0 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих цогц арга хэмжээ, 2.3 хувь нь бусад үйл ажиллагаанд зарцуулсан байна.

Зураг 25. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт зарцуулсан хөрөнгө, 2024 оны IV улирлын байдлаар

**4 598**

Хамрагдсан иргэд

**ХБИ-ийн хөдөлмөр эрхлэлтийг
дэмжих үйл ажиллагаа****9 687.0** сая төг

Зарцуулсан хөрөнгө

2,998

Санхүүгийн дэмжлэг үзүүлэх үйл
ажиллагаа

6,131.9

753

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр
эрхлэлтийг дэмжих бусад үйл ажиллагаа

2,800.5

60

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр
эрхлэлтийг дэмжих цогц арга хэмжээ

292.0

508



Хөдөлмөр эрхлэлтийн сургалт

118.1

35



Ажил олгогчийг дэмжих арга хэмжээ

244.0

244

Борлуулалтын болон ажлын байрны
түрээсийн дэмжлэгийн үйл ажиллагаа

100.5

Мэдээллийн эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газар

Түр ажлын байрыг дэмжих хөтөлбөрт 2024 оны IV улирлын байдлаар 18.0 мянган иргэн хамрагдаж, 6,815.3 сая төгрөгийг зарцуулсан байна.

Түр ажлын байрыг дэмжих хөтөлбөрт хамрагдсан иргэдийн 77.3 хувь нь нийтийг хамарсан ажил зохион байгуулахад, 15.0 хувь нь мод тарих, 6.9 хувь нь ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээнд, 0.8 хувь нь хүүхэд хамгаалагч үйлчилгээнд хамрагдсан байна. Харин зарцуулсан хөрөнгийн 63.5 хувь нь нийтийг хамарсан ажил зохион байгуулахад, 19.6 хувь нь ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээнд, 13.7 хувь нь мод тарихад, 3.2 хувь нь хүүхэд хамгаалагч үйлчилгээнд зарцуулсан байна.

Зураг 26. Түр ажлын байрыг дэмжих хөтөлбөрт хамрагдсан иргэд, зарцуулсан хөрөнгө, 2024 оны IV улирлын байдлаар

**18 014**

Хамрагдсан иргэд

**Түр ажлын байрыг дэмжих
үйл ажиллагаа****6 815.3** сая төг

Зарцуулсан хөрөнгө

142

Хүүхэд хамгаалагч үйлчилгээ

217.4

1,238



Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ

1,333.2

13,929

Нийтийг хамарсан ажил зохион
байгуулах

4,330.4

2,705



Мод тарих

934.2

Мэдээллийн эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газар

МОНГОЛ УЛСЫН ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ДУНД ХУГАЦААНЫ ЭРЭЛТ, НИЙЛҮҮЛЭЛТИЙН ТААМАГЛАЛ-2024 ОН

Таамаглалын хураангуй

Үндэсний Статистикийн Хороо нь Түүврийн жингийн тооцооллын арга зүйг 2024 оны сүүлээр шинэчилсэнтэй холбоотойгоор 2019-2023 оны Хөдөлмөрийн зах зээлийн үзүүлэлтүүдийн тоо мэдээлэлд өөрчлөлт орсон. Энэхүү судалгааны үр дүн, шинжилгээ нь тус жингийн өөрчлөлтөөс өмнө гарч дууссан бөгөөд шинэчлэгдэхээс өмнөх тоо мэдээлэлд тулгуурласан гэдгийг дурдах нь зүйтэй.

Ажиллах хүчний таамаглал

Өнгөрсөн үеийн трендийг хадгалбал 2035 онд хөдөлмөрийн зах зээл дээр 1,558.0-1,799.0 мянга, харин “Алсын Хараа 2050”-ийн зорилтыг гүйцэтгэж чадна гэж үзвэл 1,966.0 мянган ажиллах хүчин байна гэсэн өөрдөг тооцоолол гарч байна. Доорх хүснэгтэд эдгээр ажиллах хүчний оролцооны түвшин бүрийн хувьд ажиллах хүчний тоог таамагласныг үзүүлэв.

Хүснэгт 11. Ажиллах хүчний таамаглал, мянган хүн

Он	2023 оны түвшинд хадгалах	Нас, хүйсээрх АХОТ 2023 оны түвшинд хадгалах	Трендээр (шугаман)	Трендээр (квадрат)	Алсын хараа зорилт
2024	1382	1387	1372	1388	1447
2025	1406	1412	1385	1418	1538
2026	1433	1438	1401	1451	1577
2027	1462	1467	1418	1487	1619
2028	1492	1498	1437	1525	1663
2029	1524	1530	1457	1564	1709
2030	1557	1563	1476	1604	1757
2031	1589	1596	1495	1645	1801
2032	1622	1629	1514	1686	1844
2033	1653	1660	1531	1725	1887
2034	1683	1690	1546	1763	1928
2035	1709	1717	1558	1799	1966

Хэрвээ ажилгүйдлийн түвшнийг 5 орчим хувьд барьж чадвал, (Ажиллах хүчний оролцоо 2023 оны түвшинд тогтмол байна гэж үзвэл) 2025 онд 75.0 мянга, 2030 онд 80.4 мянга, 2035 онд 85.4 мянган хүн ажилгүй байна. Харин АХОТ болон ажилгүйдлийн түвшин нь “Алсын Хараа 2050”-ийн зорилтоор явна гэж үзвэл 2035 онд хөдөлмөрийн зах зээл дээр 1.97 сая ажиллах хүч, 98.3 мянган ажилгүй иргэн буюу үүний зөрүүгээр 1.87 сая ажиллагч ажиллаж байх тооцоолол гарна. Үүнтэй адилаар дээрх хувилбар бүрд ажиллагчдын тооны таамаглалыг 2035 он хүртэл гаргасан.

Хүснэгт 12. Ажилгүй иргэдийн тооны таамаглал, мянган хүн

Он	2023 оны түвшинд хадгалах	Нас, хүйсээрх АХОТ 2023 оны түвшинд хадгалах	Трендээр (шугаман)	Трендээр (квадрат)	Алсын хараа зорилт
2024	74.2	74.5	73.6	74.5	77.6
2025	75.0	75.3	73.9	75.6	82.0
2026	75.9	76.2	74.2	76.9	83.6
2027	77.0	77.3	74.7	78.3	85.2
2028	78.1	78.4	75.2	79.8	87.0
2029	79.2	79.6	75.7	81.3	88.9
2030	80.4	80.7	76.3	82.9	90.7
2031	81.6	81.9	76.7	84.4	92.4
2032	82.7	83.0	77.2	85.9	94.0

2033	83.7	84.1	77.5	87.4	95.6
2034	84.7	85.0	77.8	88.7	97.0
2035	85.4	85.8	77.9	89.9	98.3

Хүснэгт 13. Ажиллагчдын тооны таамаглал, мянган хүн

Он	2023 оны түвшинд хадгалах	Нас, хүйсээрх АХОТ 2023 оны түвшинд хадгалах	Трендээр (шугаман)	Трендээр (квадрат)	Алсын хараа зорилт
2024	1307.8	1313.0	1298.2	1313.5	1369.1
2025	1331.1	1336.3	1311.5	1342.8	1455.9
2026	1356.8	1362.0	1326.7	1374.6	1493.4
2027	1384.5	1389.9	1343.6	1408.7	1533.6
2028	1414.1	1419.6	1361.8	1445.0	1576.1
2029	1444.8	1450.6	1380.8	1482.7	1620.4
2030	1476.3	1482.2	1399.9	1521.4	1665.9
2031	1507.9	1514.0	1418.7	1560.6	1708.1
2032	1539.1	1545.5	1436.7	1599.6	1750.2
2033	1569.3	1576.0	1453.4	1637.9	1791.4
2034	1597.9	1604.8	1468.0	1674.7	1830.9
2035	1624.0	1631.2	1480.0	1709.1	1867.9

Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн таамаглалыг хийхийн тулд эрэлтийг бий болгох үйлдвэрлэл буюу дотоодын нийт бүтээгдэхүүний таамаглалыг хийж, үр дүнгээр хэр хэмжээний үйлдвэрлэлд хэдэн ажиллагч шаардлагатай болохыг тооцож гаргасан. Энэ хамаарлын коэффициентийг гаргахын тулд дэлхийн 229 улс, бүс нутгийн сүүлийн 30 жилийн нэг хүнд ногдох ДНБ, хүн амын ачаалал, дундаж нас зэрэг тоон мэдээллүүдийг ашиглан хүн амын суварга (пирамид)-ын динамик нөлөөг харгалзан үзэж ДНБ зорилтот хүрэхэд шаардлагатай хөдөлмөр эрхлэлтийн коэффициентийг үнэлж ашигласан.

ДНБ-ийн өсөлтөд шаардлагатай ажиллагчдын хоёр хувилбараар боловсруулсан ба энэ нь Хувилбар 1. Эдийн засаг жилд дунджаар 4.5 хувиар харьцангуй удаан өсөх, Хувилбар 2. Эдийн засаг хурдан өсөх буюу жилийн 7.2 хувийн дундаж өсөлт үзүүлэх үе юм.

Хүснэгт 14. Хөдөлмөр эрхлэлтийн түвшний таамаглал

Он	НХНДНБ квадрат трендээр өсөх үед		НХНДНБ холимог трендээр өсөх үед	
	ХЭТ-ий цэгэн таамаглал	95%-ийн итгэх завсар (confidence interval)	ХЭТ-ий цэгэн таамаглал	95%-ийн итгэх завсар (confidence interval)
2023	57.3		57.3	
2024	57.90	[57.54; 58.26]	57.97	[57.60; 58.33]
2025	58.80	[58.32; 59.28]	59.18	[58.65; 59.70]
2026	58.35	[57.81; 58.89]	59.05	[58.45; 59.65]
2027	58.84	[58.18; 59.49]	59.83	[59.10; 60.56]
2028	59.06	[58.28; 59.83]	60.16	[59.30; 61.03]
2029	59.46	[58.52; 60.40]	60.73	[59.68; 61.78]
2030	59.52	[58.52; 60.51]	61.06	[59.96; 62.16]
2031	59.35	[58.22; 60.48]	61.01	[59.76; 62.26]
2032	59.58	[58.31; 60.85]	61.39	[59.98; 62.81]
2033	59.66	[58.31; 61.01]	61.37	[59.86; 62.87]
2034	59.86	[58.30; 61.43]	61.80	[60.04; 63.57]
2035	60.04	[58.40; 61.68]	62.12	[60.25; 63.98]

Дээрх хөдөлмөр эрхлэлтийн түвшнийг ашиглан ДНБ-ий хоёр хувилбарт таамаглал тус бүрийн хувьд шаардагдах хөдөлмөрийг тооцоолсон.

Хүснэгт 15. Шаардлагатай ажиллагчдын тооны таамаглал, мянган хүн

Он	Нэг хүнд ногдох ДНБ Квадрат трендээр өсөх үед	Нэг хүнд ногдох ДНБ Холимог трендээр өсөх үед	ДНБ квадрат өсөлт	ДНБ холимог өсөлт
2024	1,380.3	1,384.4	2.0%	2.3%
2025	1,410.0	1,418.4	2.2%	2.5%
2026	1,442.4	1,455.2	2.3%	2.6%
2027	1,477.3	1,494.7	2.4%	2.7%
2028	1,514.2	1,536.4	2.5%	2.8%
2029	1,552.7	1,579.9	2.5%	2.8%
2030	1,592.1	1,624.6	2.5%	2.8%
2031	1,632.0	1,669.8	2.5%	2.8%
2032	1,671.7	1,715.1	2.4%	2.7%
2033	1,710.5	1,759.7	2.3%	2.6%
2034	1,747.7	1,802.8	2.2%	2.5%
2035	1,782.5	1,843.5	2.0%	2.3%

Хэрэв 7.2 хувийн эдийн засгийн дундаж өсөлттэй байвал Монгол Улсын хөдөлмөрийн зах зээл дээр 2025 онд 1,418 мянга, 2030 онд 1,625 мянга, 2035 онд 1,844 мянган хүн ажиллаж байх шаардлагатай байна. Харин өнөөгийн өсөлтийн трендийг хадгалж 4.5 хувийн өсөлтийг хангана гэж үзвэл 2025 онд 1,410 мянга, 2030 онд 1,592 мянга, 2035 онд 1,783 мянган ажиллагчид хөдөлмөрийн зах зээл дээр шаардлагатай байна.

Дээрх тооцоолсон 2035 он хүртэлх эдийн засгийн өсөлтөд шаардлагатай ажиллагчдын тоог эдийн засгийн үйл ажиллагааны салбараар тооцон харууллаа. Ингэхдээ ҮСХ-ны 2009-2023 онд хийгдсэн АХС-ны мэдээлэлд дүн шинжилгээ хийж ажиллагчдын салбарын бүтцийг тодорхойлсон бөгөөд уг бүтцээр шаардлагатай ажиллагчдын дүнг тархаасан.

Эдийн засаг “Алсын Хараа 2050” зорилтод хүрэхүйц харьцангуй хурдан өсөх үед: 2035 он гэхэд хамгийн их ажиллагч шинээр шаардлагатай салбар нь барилгын салбар бөгөөд 2024 онтой харьцуулахад 88.1 мянга ажиллагч, удаах нь боловсруулах үйлдвэрлэлийн салбарт 69.8 мянга, Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар, үйлчилгээ салбарт 53.4 мянга, Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгааллын салбарт 41.2 мянган ажиллагч шинээр шаардлагатай байна. Харин ХАА, ойн аж ахуй, загас барилт салбар нь 2035 онд манай улсын хамгийн олон ажиллагчтай салбар хэвээр байх боловч 2-13.6 мянган ажиллагчаар буурах төлөвтэй байна.

Хүснэгт 16. Шаардлагатай ажиллагчдын тоо, салбараар таамаглал, ДНБ-ий таамаглалын холимог трендээр, мянган хүн

	2024	2025	2026	2027	2028	2029	2030	2031	2032	2033	2034	2035
ХАА, ойн аж ахуй, загас барилт	320.1	319.1	318.4	318.0	317.7	317.4	316.9	316.1	314.8	312.8	310.1	306.5
Уул уурхай, олборлолт	70.9	73.3	75.8	78.4	81.1	83.9	86.7	89.5	92.4	95.2	98.0	100.6
Боловсруулах үйлдвэрлэл	123.3	128.6	134.2	140.1	146.2	152.6	159.2	165.9	172.7	179.6	186.4	193.1
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	24.3	25.5	26.9	28.3	29.8	31.3	33.0	34.6	36.4	38.1	39.9	41.7

Усан хангамж; бохир ус зайлуулах систем, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	9.4	9.4	9.5	9.6	9.6	9.7	9.7	9.8	9.8	9.8	9.8	9.8
Барилга	99.1	105.0	111.4	118.4	125.8	133.7	142.0	150.7	159.6	168.8	178.0	187.2
Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар, үйлчилгээ	192.1	196.6	201.4	206.4	211.7	217.1	222.6	227.9	232.9	237.7	241.9	245.5
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	72.2	72.1	71.9	71.9	71.8	71.7	71.6	71.4	71.2	70.8	70.2	69.5
Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	42.3	44.2	46.4	48.7	51.1	53.7	56.3	59.0	61.8	64.5	67.2	69.8
Мэдээлэл, холбоо	20.5	21.4	22.3	23.3	24.3	25.4	26.5	27.7	28.8	30.0	31.1	32.1
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	32.3	34.6	37.2	40.0	43.0	46.3	49.7	53.4	57.3	61.3	65.4	69.6
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	2.9	3.3	3.8	4.2	4.8	5.4	6.1	6.9	7.8	8.8	10.0	11.2
Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	17.9	18.5	19.2	19.9	20.6	21.4	22.1	22.9	23.7	24.4	25.2	25.9
Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	22.8	24.7	26.7	29.0	31.4	34.1	36.9	40.0	43.2	46.6	50.1	53.8
Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	99.4	102.7	106.2	109.8	113.6	117.5	121.4	125.4	129.3	133.2	137.0	140.6
Боловсрол	125.7	128.5	131.5	134.5	137.6	140.7	143.8	146.9	149.9	152.7	155.4	157.7
Хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа	58.6	59.4	60.3	61.3	62.2	63.1	64.0	64.8	65.6	66.4	67.1	67.6
Урлаг, үзвэр, тоглоом, наадам	15.1	15.9	16.9	17.9	19.0	20.2	21.4	22.7	24.0	25.3	26.7	28.0
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	35.5	35.4	35.2	35.1	34.9	34.7	34.5	34.3	34.0	33.8	33.5	33.1
Нийт	1384.4	1418.4	1455.2	1494.7	1536.4	1579.9	1624.6	1669.8	1715.1	1759.7	1802.8	1843.5

Монгол Улсын хэмжээнд Үндэсний ажил мэргэжлийн ангилал, тодорхойлолт (YAMAT-08)-ын дагуу үндсэн 10 мэргэжлээр 2035 он хүртэлх шаардлагатай ажиллагчдыг таамагласан. Ингэхдээ ҮСХ-ны Ажиллах хүчний судалгааны 2009-2023 оны өгөгдлийг ашиглан шинжилгээ хийсэн бөгөөд салбар-ажил мэргэжил бүтцийг нэг орны түвшинд тодорхойлж, гулсуулсан дундаж (moving average)-ийн засварлан трендийн матрицыг тооцож үр дүнг тархаасан.

Хүснэгт 17. Шаардлагатай ажиллагчдын тоо, ажил мэргэжлээрх таамаглал, ДНБ-ий таамаглалын холимог трендээр өсөх үед, мянган хүн

	2024	2025	2026	2027	2028	2029	2030	2031	2032	2033	2034	2035
Менежер	91.5	95.0	98.8	102.8	107.1	111.5	116.2	120.9	125.8	130.8	135.7	140.5
Мэргэжилтэн	240.5	248.2	256.4	265.0	274.1	283.5	293.2	303.0	313.0	323.0	332.8	342.3
Техникч болон туслах/ дэд мэргэжилтэн	55.8	57.7	59.7	61.9	64.2	66.6	69.1	71.7	74.3	76.9	79.6	82.2
Контор, үйлчилгээний ажилтан	42.0	43.6	45.4	47.4	49.4	51.6	53.8	56.1	58.5	60.9	63.3	65.6
Худалдаа, үйлчилгээний ажилтан	227.7	234.0	240.8	248.0	255.5	263.4	271.4	279.4	287.4	295.2	302.6	309.5
ХАА, ой, загас агнуурын мэргэшсэн ажилтан	313.7	312.8	312.2	311.9	311.7	311.6	311.2	310.5	309.3	307.4	304.9	301.5
Үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил, үйлчилгээний ажил	169.7	177.0	184.8	193.1	201.9	211.1	220.7	230.5	240.5	250.6	260.7	270.6
Машин механизм, төхөөрөмжийн операторч, угсрагч	124.1	126.7	129.4	132.3	135.4	138.7	141.9	145.2	148.5	151.7	154.8	157.7
Энгийн ажил, мэргэжил	113.1	116.9	120.9	125.3	129.8	134.6	139.5	144.5	149.6	154.7	159.7	164.6
Зэвсэгт хүчний ажил, мэргэжил	6.3	6.5	6.7	7.0	7.2	7.4	7.7	7.9	8.2	8.4	8.7	8.9
Нийт	1384.4	1418.4	1455.2	1494.7	1536.4	1579.9	1624.6	1669.8	1715.1	1759.7	1802.8	1843.5

ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ

Хөдөлмөрийн насны хүн ам гэж 15, түүнээс дээш насны хүн амыг хэлнэ. Хөдөлмөрийн насны хүн амыг ажиллах хүч болон ажиллах хүчнээс гадуурх хүн ам гэж ангилна.

Ажиллах хүч гэж тухайн хугацаанд зөвхөн хөдөлмөр эрхлэлтийн ажлын хэлбэрийн хүрээнд, цалин хөлс, орлого олох зорилгоор бусдын хэрэглээнд зориулан бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үйлчилгээ үзүүлэхэд хүч хөдөлмөрөө нийлүүлж байгаа ажиллагчид болон нийлүүлэхэд бэлэн байгаа ажилгүй хүн юм.

Ажиллах хүчнээс гадуурх хүн ам гэж сургуульд суралцаж байгаа, гэрийн ажилтай, өндөр настан, өндөр насны тэтгэвэр тогтоолгосон, хөгжлийн бэрхшээлтэй болон ажил хайх итгэл алдарсан зэрэг шалтгаанаар тухайн хугацаанд ажиллах хүчинд хамаарахгүй хөдөлмөрийн насны хүн амыг ойлгоно. Ажиллах хүчнээс гадуурх хүн амаас боломжит ажиллах хүчийг тодорхойлно. Мөн ажиллах хүч болон боломжит ажиллах хүч хоёрын нийлбэрээр өргөтгөсөн ажиллах хүч илэрхийлэгдэнэ.

Хөдөлмөрийн дутуу ашиглалт гэж хөдөлмөрийн нийлүүлэлт болон эрэлтийн зөрүү буюу хөдөлмөрийн насны хүн амын хөдөлмөр эрхлэлтийн хэрэгцээ хангагдахгүй байхыг ойлгоно.

Цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэгч гэж тухайн хугацаанд хөдөлмөр эрхэлж буй ажиллагчийн бүх ажлынх нь ажлын цаг нь үндэсний хууль тогтоомжид заасан босго цагаас бага бөгөөд өөр ажил хийх хүсэлтэй, нэмэлт цагаар ажиллахад бэлэн байгаа хүнийг ойлгоно. Босго цаг гэдгийг Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуульд заасны дагуу 7 хоногийн ажлын 5 өдрийн 40 цагаар авч үзнэ.

Ажилгүй хүн гэж сүүлийн 7 хоногт хөдөлмөр эрхлээгүй, хөдөлмөр эрхлэх зорилгоор ажил хайж байгаа болон ажил хийхэд бэлэн байгаа хөдөлмөрийн насны хүн юм.

Боломжит ажиллах хүч гэж цалин хөлс, орлого олох зорилгоор хөдөлмөр эрхлэхийг сонирхож байгаа боловч тодорхой нөхцөл байдлын улмаас ажил хайх оролдлого нь хязгаарлагдсан эсвэл шууд ажил хийх боломжгүй байгаа, тухайн хугацаанд хөдөлмөр эрхлээгүй хүн юм.

Ажиллах хүчний оролцооны түвшин: Ажиллах хүчний тоог хөдөлмөрийн насны хүн амын тоонд харьцуулж тооцно.

$$АХОТ = \frac{\text{Ажиллах хүч}}{\text{Хөдөлмөрийн насны хүн ам}} * 100\%$$

Хөдөлмөр эрхлэлтийн түвшин: Ажиллагчдын тоог хөдөлмөрийн насны хүн амын тоонд харьцуулж тооцно.

$$ХЭТ = \frac{\text{Ажиллагчдын тоо}}{\text{Хөдөлмөрийн насны хүн ам}} * 100\%$$

Даатгуулагч гэж хууль болон гэрээний үндсэн дээр нийгмийн даатгалын санд нийгмийн даатгалын шимтгэл төлж даатгуулсан, нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийг хэлнэ.

Нийгмийн даатгалын шимтгэл гэж нийгмийн даатгалд даатгуулах зорилгоор иргэн болон төр, ажил олгогчоос нийгмийн даатгалын санд хуульд заасан хувь хэмжээгээр урьдчилан төлөх төлбөрийг хэлнэ.

Ажилгүйдлийн тэтгэмж гэж ажилгүй болохоосоо өмнө ажилгүйдлийн даатгалын шимтгэлийг хуульд заасан болзол, журмын дагуу төлсөн даатгуулагч ажилгүй болсон бол түүнд нийгмийн даатгалын сангаас олгох мөнгөн хөрөнгийг хэлнэ.

Дундаж цалин гэж тайлант хугацаанд цалин, хөлс авсан ажиллагчдын тоогоор жигнэсэн нийт цалин хөлс болон тайлант хугацаанд цалин хөлс авсан ажиллагчдын тооны харьцаа юм.

Нэрлэсэн цалин гэдэг нь тодорхой хугацаанд хийсэн хөдөлмөрийнхөө төлөө авч буй мөнгөн төлбөрийн дүн юм.

Ажил хайгч иргэн гэж ажилгүй эсхүл ажилтай боловч ажлын нөхцөлөө сайжруулах, нэмэлт орлого олох зорилгоор ажил хайж байгаа иргэнийг ойлгоно.

Бүртгэлтэй ажилгүй иргэн гэж хөдөлмөрлөх насны, хөдөлмөр эрхлэх чадвартай, цалин хөлстэй ажил болон хувиараа хөдөлмөр эрхэлдэггүй, тухайн үед ажиллахад бэлэн, цалин хөлстэй ажил идэвхтэй хайж байгаа хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс, хөдөлмөрийн хувийн биржид бүртгүүлсэн ажилгүй иргэдийг хамруулна.

Байнгын ажлын байр гэж ажил олгогчийн заасан ажлын байранд, тогтоосон горимын дагуу түүнээс олгосон хөдөлмөрийн багаж хэрэгслээр, ажил олгогч, эсхүл түүний төлөөлөгчийн удирдлагын дор баталсан норм, үнэлгээ, сүлжээгээр цалин хөлс авч, ажлын өдөр, ээлжийн давтамжтайгаар гүйцэтгэх ажил үүргийг;

Байнгын ажилтан нь байнгын ажлын байранд ажиллах албан ёсны гэрээтэй бөгөөд ажил олгогч нь татвар болон нийгмийн даатгалын шимтгэлийг хариуцан төлдөг, хөдөлмөрийн харилцаа нь хөдөлмөрийн тухай болон төрийн албаны тухай хууль тогтоомжоор зохицуулагддаг иргэнийг;

Албан бус ажил олгогч гэж тогтмол хугацаанд нэг буюу түүнээс дээш хүнийг цалин хөлстэй ажиллагчаар ажиллуулдаг хувиараа хөдөлмөр эрхлэгч. Цаашид энэ ангиллын албан бус хөдөлмөр эрхлэгчдийг ажил олгогч гэж нэрийднэ.

Ажиллагч албан бус хөдөлмөр эрхлэгч гэж хөдөлмөрийн харилцаа нь хууль эрх зүйн хүрээнд бүрэн зохицуулагдаагүй нөхцөлд ажиллаж буй цалин хөлстэй ажиллагч. Цаашид ажилтан энэ ангиллын албан бус хөдөлмөр эрхлэгчдийг ажилтан гэж нэрийднэ.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. Монгол Улсын “Хөдөлмөрийн тухай” хууль, 2021 он
2. “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай” хууль, 2011 он
3. Хөдөлмөр эрхлэлтийн статистикийн үзүүлэлтийг тооцох аргачлал, Үндэсний статистикийн хороо, 2019 он
4. Ажиллах хүчний судалгааны тайлан, Үндэсний статистикийн хороо, 2024 оны III улирал
5. Нийгмийн даатгалын хамрагдалт, тэтгэвэр, тэтгэмж авагчдын сарын мэдээ, Нийгмийн даатгалын ерөнхий газар
6. Ажил хайгч иргэний хөдөлгөөний сарын мэдээ, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар
7. Бүртгэлтэй ажилгүй иргэний хөдөлгөөний сарын мэдээ, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар
8. Ажлын байрны захиалга, ажилд зуучлагдсан иргэдийн мэдээ, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар
9. Хөдөлмөрийн зах зээлийн тойм 2024 оны III улирал
10. Монгол улсын хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн дунд хугацааны таамаглал -2024 он

АШИГЛАСАН ЦАХИМ ХУУДАС

1. www.legalinfo.mn
2. www.1212.mn
3. www.mlsp.gov.mn/sp-dictionary